



ISSUE #8

14 October 2011

## ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн Байцаана уу,

ОУДС-ийн үйл ажиллагааг дэлхийн бусад олон улсын сургуулиудад тавигддаг стандартын дагуу үнэлэх магадлан итгэмжлэлийн шалгалтын багийн айлчлал долоо хоног явагдаж дууслаа. Шалгалтын ажлын нэгдсэн тайлан гарах болоогүй хэдий ч багийн ахлагч манай 5 жилийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажил амжилттай явагдаж байгааг онцлон тэмдэглэсэн. Учир нь энэ 5 жилийн төлөвлөгөө зүгээр нэг цаасан дээр буугаад тоосонд дарагдаагүй ажил хэрэг болж байгааг тэд онцлон тэмдэглэсэн.



Энэ долоо хоногийн Мэдээгээр стратеги төлөвлөгөөний зургаан гол зорилтын анхны зорилт болох боловсролын зорилтын талаар бид та бүхэнд товч танилцуулъя.

*Боловсролын талаар:*

### **ЗОРИЛТ**

Бид олон улсын баклавриатын байгууллагын хөтөлбөрийн хүрээнд сурагчдад тэнцвэртэй боловсрол олгох программыг хэрэгжүүлдэг бөгөөд сургалтын хөтөлбөртөө Монгол орны өвөрмөц онцлог соёл заншлыг тусгаж өгдөг.

ОУДС-ийг дэлхийн түвшинд хүрсэн их сургуулийн бэлтгэл сургууль болгохын тулд танхимын болон танхимаас гадуурх сургалтын хөтөлбөрийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх, англи хэл, төрөлх хэлний сургалтыг сайжруулах, сурагчдын онцлогт тохирсон сургалтын олон аргыг хэрэглэх шаардлагатай.



ОУДС-нь Монгол орны өвөрмөц онцлог, соёл заншилд тулгуурлан сурагчдад бүх талын өв тэгш, тэнцвэртэй боловсрол олгох өргөн боломжтой. Эдгээр боломжуудыг бид сургалтын ажилтай нягт уялдуулж сурагчдын мэдлэгийн хүрээг тэлж, олон орны соёл заншлын онцлог, ялгааг ойлгох, харилцан хүндэтгэх, цаашид байнга суралцах эрмэлзлийг сурагчдад эзэмшүүлнэ.

# THE MEEDEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar

## Боловсролын талаар:

- Сурагчдад ИВ байгууллагын хөтөлбөрийг эзэмшүүлэх
- Сурагчдын сахилга бат, зан чанарын төлөвшилтийг сайжруулах тодорхой арга барилыг боловсруулах
- Бүх ангийн сурагчдад тохирсон ёс зүйн хөтөлбөрийг боловсруулах
- Сургалтын хөтөлбөр бүх түвшинд тохирч байгааг тодорхойлсон, сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх хэмжүүрийг цаашид боловсруулах
- Бүх сурагчдын суралцах арга барилд нийцсэн сургалтыг нэвтрүүлэх
- Бэлтгэл ангиас 10-р ангийн сурагчдын унших болон тооны хичээлийн оноог сайжруулах, төгсөх сурагчдын дипломын хөтөлбөрийн мэдлэгийг сайжруулах хичээлүүдийн хөтөлбөрт дүгнэлт хийж дахин боловсруулах
- Нийгэмд чиглэсэн танхимаас гадуур суралцах боломжуудыг танхимын хөтөлбөртэй уялдуулах
- Сурагчдын мэдлэг, сонирхол, авъяас, боломжинд нийцсэн их дээд сургуулиудад тэднийг элсүүлэх хөтөлбөрийг боловсруулах
- Сурагчдыг орчин үеийн технологийн дэвшилд сургаж тэдэнд гүнзгий мэдлэг эзэмшүүлж өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд амьдарч ажиллах чадвартай болгож бэлтгэх
- Бэлтгэл ангиас 12-р ангийн сурагчдын түвшинд тохирсон хэлний хөтөлбөр боловсруулах

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд өнгөрсөн жилд болон энэ хичээлийн жил эхлээд нэлээд ажил хийгээд байна. Даваа гарагийн үдээс хойш манай багш нар Бага болон Дунд Сургуулийн хөтөлбөрийн хүрээнд хичээл хоорондын уялдааг сайжруулах төлөвлөгөөг боловсруулах ажлыг багаар зохион байгуулж хийж байна. Манай багш нар ИВ байгууллагын хөтөлбөрт хэрэглэгддэг ManageBac компьютерийн програмыг ашиглах сургалтанд хамрагдсан бөгөөд ирэх сараас эхлэн Дунд Сургуулийн 1-р улирлын дүнг гаргахад болон Дипломын сурагчдын CAS хөтөлбөрт уг програмыг анх удаа хэрэглэх гэж байна. Манай хэсэг багш, туслах багш нар санаачлан хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Mongolia Institute of Outdoor Learning байгууллагын туршлагыг хэрэглэн Дунд Сургуулийн сурагчдын залуу аялагчдын клубын гишүүд хичээлээс гадуурх явган аялалуудыг зохион байгуулж хотын ойролцоох уулнуудад авиралт хийж байгаль орчныг хамгаалах, цэвэрлэх ажлуудыг хийж байна. Хичээлээс гадуур урлагийн дугуйлангууд бас хичээллэж байна.

Их Дээд Сургуулийн Элсэлтийн Зөвлөгч багш маань төгсөх ангийн сурагчидтай ажиллаж тэдэнд их дээд сургуулиудад элсэх материалаа бүрдүүлэхэд нь тусалж байна. Саяхан тэрээр Хонг Конгод айлчилж бусад олон улсын сургуулиудын зөвлөгч багш нартай уулзаж туршлага судалсан бөгөөд мөн энэ үеэр зохиогдсон Их Дээд Сургуулиудын элсэлтийн өдөрлөгт оролцоод ирлээ.

Мэдээллийн Технологийн ажлын хүрээнд сургуулийн дотоод сүлжээг сайжруулах, хуучин компьютерүүдийг шинэчлэх ажлуудыг хийгээд байна. Үүнтэй уялдуулан бид сурагчиддаа нийгэмд үйлчлэх төсөл хэрэгжүүлэх боломжийг олгох болно. Жишээ нь хуучин компьютерийг ашиглан орон нутгийн ТББ-д лаборатор нээх, эсвэл гэр хороололд интернет кафе нээж сурагчид өөрсдөө сургалт явуулж, техникийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах гэх мэт.

Стратеги төлөвлөгөөний хүрээнд 5 жилд бид их ажлыг хийх болно. Энэ төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар бид бас энэ хичээлийн жилийн төгсгөлд дүгнэлт хийх болно.

Ирэх долоо хоногт сурагчдын намрын амралт учир Мэдээ гарахгүй. Сурагчдын хичээл 10 сарын 26-ны Лхагва гарагт эхэлнэ. Даваа, Мягмар гарагт манай багш нар мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдана.

Та бүхэн сайхан амраарай.

Захирал Robert Stearns

## ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

10 сарын 17-25

Намрын Амралт

10 сарын 24, 25

Багш нарын мэргэжил дээшлүүлэх өдөр

10 сарын 26

Сурагчдын хичээл эхэлнэ

## Олон Улсын Долоо Хоног

ОУДС жил бүр Олон Улсын Долоо Хоног арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ жил бид энэ арга хэмжээг 2011 оны 11 сарын 14-18-ны хооронд тэмдэглэн өнгөрүүлнэ.

**Олон улсын долоо хоногийн үеэр 11 сарын 16-ны Лхагва гарагт интернационализм-ийн утга учрыг таниулах олон төрлийн арга хэмжээнүүд зохиогдоно.**

**Олон Улсын Долоо Хоногийн үеэр 11 сарын 17-нд Олон Үндэстний Жагсаалын дараа урлагийн тоглолт үзүүлэх хүсэлтэй хүмүүс Мэдээний Англи эх хувьд хавсрагдсан хуудсыг бөглөж бидэнд ирүүлнэ үү.**

Хэрвээ та бүхэн эдгээр арга хэмжээнд оролцож өөрийн орны талаар товч яриа хэлэлцүүлэг хийх, кино үзүүлэх, тоглоом тоглуулах, гар урлалын зүйлсийн үзэсгэлэн болон бусад арга хэмжээг сурагчдын дунд зохион байгуулах буюу урлагийн тоглолт үзүүлэх хүсэлтэй бол дараах багш нартай холбоо барина уу:

Ms. Maggie Dawson [m.dawson@isumongolia.edu.mn](mailto:m.dawson@isumongolia.edu.mn)

Ms. Erdenetsetseg [e.bayandorj@isumongolia.edu.mn](mailto:e.bayandorj@isumongolia.edu.mn)

Mr. McCutcheon [e.mccutcheon@isumongolia.edu.mn](mailto:e.mccutcheon@isumongolia.edu.mn)

## Дунд Сургуулийн Мэдээ

1-р улирлын сүүлчийн долоо хоногт дунд сургуулийн сурагчид олон зүйлийг хийж гүйцэтгэлээ. Биологийн ангийн сурагчид тахианы хөлд шинжилгээ хийж, ТОК-ийн сурагчид презентаци хийж, Дизайн Технологийн хичээлээр сурагчид гэр хорооллын талаар слайд хийж, 6-р ангийн сурагчид газрын зураг дээр ажиллаж дэлхийн улсуудын нийслэлийн талаар судалсан. Манай багш нар та бүхний хүүхдүүдэд хичээлээрээ сонирхолтой сэдвүүдийг зааж сургадаг. Та бүхэн сурагчдаас өөрсдөөс нь энэ талаар дэлгэрэнгүй асуугаарай.

Волейболын тамирчид маань АСАМИС тэмцээний өмнө 20-р сургууль болон Америкийн дунд сургуулийн багуудтай тэмцээн зохиолоо. Сурагчид маань амралтын сүүлийн өдөр Бээжин рүү тэмцээнд оролцохоор явна.

Энэ өнгөрч буй долоо хоногт манай сургууль дээр IB, CIS, NEASC гурван байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгалтын багийхан айлчилж бид нэлээд завгүй байлаа. Айлчлалын багийхантай ирж уулзсан эцэг эхчүүддээ болон багш нар, сурагчид, удирдах зөвлөлийн гишүүддээ баярлалаа. Манайх сайн сургууль бөгөөд мэргэжлийн бусад хүмүүс үүнийг харж илүү сайн болгох талаар зөвлөгөө өгөх нь чухал байдаг.

Намрын амралтаа сайхан өнгөрүүлээрэй!

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

## **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Сурагчдын тоглоомын талбайг шинэчлэх ажил дуусч тоглоомуудыг суурилуулсан байгааг хараад бид баяртай байна. Намрын амралтаас орж ирээд сурагчид тоглоход тоглоомын талбай бэлэн болсон.

Halloween –ы өдрийг ангиуд 10 сарын 28-ны Баасан гарагт анги ангидаа 2:10-2:50-д тэмдэглэнэ. Энэ өдөр хүүхдүүд “дүрд хувирахдаа өмсөх костюмаа” авчраад ангидаа сольж өмсөнө. Хэрвээ та бүхэн энэ өдрийг тэмдэглэхэд туслах хүсэлтэй бол ангийн багш нартай нь холбоо бариарай.

Намрын амралтаа сайхан өнгөрүүлээрэй!

**Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya**